



ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 15 өдөр

Дугаар Б/08

Жаргалтхаан сум

Э.Хуланг ажилд томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 93 дугаар зүйлийн 93.1, 99 дүгээр зүйлийн 99.1, 99.2, 99.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Боловсролын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрдэнэбатын Хулан нь туршилтын хугацаанд төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаагүй, ажлын гүйцэтгэлийн шалгуурыг хангасан тул 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс нярвын үүрэгт ажилд томилсугай.

2. Э.Хулан нь ТҮ-4 дүгээр шатлал, 1657500 (нэг сая зургаан зуун тавин долоон мянга таван зуу) төгрөгөөр цалинжуулж, холбогдох нэмэгдэл, урамшууллыг зохих хууль тогтоомж, журмын дагуу олгохыг нягтлан бодогч (Г.Урансүх)-д зөвшөөрсүгэй.

3. Сургуулийн нярвын ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж, эд хогшлын бүрэн бүтэн байдал, бүртгэлд хяналт тавьж, тооцоо, тооллогыг цаг тухайд нь хийж гүйцэтгэх, тайлагнах, дотуур байр, үдийн цай хөтөлбөрийн хүнсний материалын хангалтыг хариуцан, чанарын шаардлагыг хангуулж ажиллахыг нярав Э.Хуланд үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Э.Хуланг ажилд томилох тухай" захирлын 2025 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн Б/51 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

C. Оюунцэцэг

С.ОЮУНЦЭЦЭГ



D/Tushaal-2026
232601015